

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ДЭД САЙД С.ДАВААСҮРЭНГИЙН ХБНГУ-ЫН ҮНДЭСНИЙ БАЯРЫН ХҮЛЭЭН АВАЛТАД ХЭЛЭХ ҮГ

2026 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 16:00 цагт, Германы ЭСЯ-ны байранд

Эрхэмсэг ноён Элчин сайд Томас Граф,
Эрхэм хүндэт Дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нар,
Олон улсын байгууллагуудын зочид төлөөлөгчид өө,
Хүндэт зочид, хатагтай, ноёд оо,

Герман Улс даяар эрх чөлөө, энх тайван, ардчиллын үнэт зүйлс ялан дийлсэн энэхүү түүхэн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа Эрхэмсэг ноён Элчин сайд Танд болон хуран цугларсан эрхэм зочид Та бүхэнд чин сэтгэлийн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Мөн энэ ташрамд Монгол Улсад суугаа Элчин сайдаар томилогдон ажиллаж буй ноён Томас Граф Танд өндөр амжилт хүсэхийн ялдамд Монгол, Германы уламжлалт найрсаг харилцаа, стратегийн түншлэл Таны бүрэн эрхийн хугацаанд улам бүр бэхжин хөгжинө гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлье.

Монгол, Герман хоёр орны харилцаа гүн гүнзгий түүхэн үндэстэй билээ. Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж тэргүүтэй Монголын анхны оюутнууд Өрнөдөд буюу Германд суралцахаар мордсоны түүхт 100 жилийн ой энэ онд тохиож байна. Энэ нь манай хоёр ард түмнийн оюун санаа, боловсролын харилцаа дипломат харилцаа тогтоохоос ч өмнө эхэлснийг гэрчилж байна.

Манай хоёр улс нь ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёс зэрэг нийтлэг үнэт зүйлсэд суурилсан төдийгүй Герман Улс нь манай улсын Европ дахь чухал түнш, итгэлт хамтрагч “гуравдагч хөрш” юм. Энэ нийтлэг үнэт зүйлс, харилцан итгэлцэл нь өнөөгийн Стратегийн түншлэлийн бат бөх суурь болж байна.

Герман Улс Монгол Улсын ардчилал, шинэчлэлийн үйл явцыг олон жилийн турш тууштай дэмжиж ирсэн бөгөөд хөгжлийн хамтын ажиллагаагаар дамжуулж нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны хамгаалал, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсаар ирснийг бид өндрөөр үнэлдэг.

Өнөөдөр манай хоёр улсын хамтын ажиллагаа улс төр, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон салбарт идэвхтэй өргөжин хөгжиж байна. Түүнчлэн өндөр, дээд түвшний

айлчлал, улс төрийн яриа хэлэлцээ тогтмолжиж, харилцааны агуулга улам баяжиж байгаад сэтгэл хангалуун байдаг.

Газар зүйн алслагдмал байрлал харгалзахгүйгээр, Герман Улс нь Монгол Улсын Европын холбоо дахь худалдаа, эдийн засгийн гол түнш байсаар ирсэн. Хоёр талын бараа эргэлт 2025 оны байдлаар 293.1 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 12 хувиар өссөн, гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 350.6 сая ам.долларт хүрсэн байна. Цаашид бидэнд харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагааг илүү өргөн хүрээнд хөгжүүлэх боломж ихээхэн бий. Ялангуяа Герман Улсын хөрөнгө оруулалт, технологи, менежментийн туршлагыг Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан эрчим хүч, дэд бүтэц, ашигт малтмал, геологийн хайгуул, өндөр технологи болон ногоон хөгжлийн салбаруудад хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэхийн төлөө байх болно.

Эрхэм зочид оо,

Монгол Улсын Засгийн газар эдийн засгаа төрөлжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны шинэ зах зээлийг хөгжүүлэх, хувийн хэвшил хоорондын шууд түншлэл, харилцааг дэмжихэд онцгой ач холбогдол өгч байна.

Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтыг татахын зэрэгцээ урт хугацааны, харилцан итгэлцэлд суурилсан түншлэлийн орчныг бүрдүүлэхийг зорьж байна. Энэ хүрээнд Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг баталж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, төрийн хэт оролцоог бууруулах, бизнес эрхлэх ил тод, тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн томоохон шинэчлэлийг хэрэгжүүлж эхлээд байна.

Мөн энэхүү шинэчлэлийн хүрээнд бизнес эрхлэхэд саад болж буй давхардсан, шаардлагагүй зохицуулалтыг үе шаттайгаар цэгцэлж, хувийн хэвшлийн өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Бид хоёр улсын Стратегийн түншлэлийг эдийн засгийн бодит агуулгаар баяжуулж, хөрөнгө оруулалт, худалдаа, үйлдвэрлэл, дэвшилтэт техник, технологийн хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэхийг эрмэлзэж байгаагаа онцлон тэмдэглье.

Эцэст нь, Герман Улс Нэгдсэн өдрийг тохиолдуулан Германы ард түмэнд аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэж, хоёр улсын Стратегийн түншлэл улам бүр бэхжин хөгжихийн ерөөлийг өргөн дэвшүүлье.

Баярлалаа.